

# Хүүхэд холбох хүсэлт илгээх заавар

## Хүүхэд холбох хүсэлт

Эцэг эх хүүхэд холбох хүсэлт илгээхэд дараах дарааллыг баримтална.

### Эцэг, эх:

1. **Системд бүртгүүлэх** - parent.edu.mn хаягаар нэвтрэн орж шинэ хэрэглэгчээр бүртгүүлнэ.
2. **Хүүхэд холбох хүсэлт илгээх** - Системд нэвтрэн орж хүүхдийн нэмэх хүсэлтийг QR кодоор эсвэл гараар шивж өөрийн хүүхдийн мэдээлэл харах хүсэлтээ ангийн багшид илгээх боломжтой болно.


Дээрх 2 үйлдлийг хийсэн байхад л ангийн багш таны илгээсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ.

### Багш:


3. **Ангийн багш хүсэлтийг баталгаажуулах** - Эцэг, эх асран хамгаалагчаас ирсэн хүсэлтийг Ангийн багш нягтлаад баталгаажуулах эсвэл татгалзах үйлдэл хийнэ.
4. **Хүүхдийн сурлагын мэдээлэл хүлээн авах** - Хүүхэд холбох хүсэлтийн баталгаажуулалт хийгдсэнээр эцэг, эх, асран хамгаалагч хүүхдийн ирц, сурлагын болон байгууллагын мэдээлэлтэй танилцах боломжтой.

Эцэг эх **хүүхэд нэмэх** үйлдэл хийхэд дараах алхамчилсан дарааллын дагуу хийнэ.


1. Эцэг эх хэрэглэгчийн эрхээр системд нэвтрэн орно.



2. Дараах цонх харагдах бөгөөд зүүн буланд байрлах цэснүүдээс **хүүхэд холбох** гэсэн цэсийг сонгож дэлгэцийн баруун гар талд байрлах нэмэх товчийг дарж орно.




3. **Хүүхэд нэмэх** товчийг дарахад дараах цонх гарч ирэх бөгөөд хүүхэд холбоход 2 сонголттой байна.



Хүүхэд холбох хүсэлтийг **QR кодоор хүүхэд холбох** эсвэл **Гараар шивэх** гэсэн 2 сонголтоор бүртгэл хийнэ.

- **QR Кодоор хүүхэд холбох хэсэг дараах байдлаар харагдана.**

**Камертай тохиолдолд** суралцагчийн QR кодийг уншуулна.



- **Гараар шивэх гэсэн хэсэг нь дараах байдлаар харагдах бөгөөд холбох хүүхдийн мэдээллийг оруулж**

үргэлжлүүлэх товчийг дарна.

Нүүр

Миний хүүхдүүд

Хүүхэд сонгох

Хүүхэд нэмэх

ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУМЖ

Хүүхдийн жагсаалт

+ Хүүхэд нэмэх

1 Холбосон хүүхэд байхгүй байна.

Хүүхэд холбох

1 Алхам 1

2 Алхам 2

Хүүхдийн хэн болох

A A Хүүхдийн регистрийн дугаар

Эцэг/эх-ийн нэр

Хүүхдийн нэр

БУЦАХ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ

Ингэснээрээ таны хүүхэд холбох хүсэлт анги удирдсан багшид харагдах бөгөөд ангийн багш илгээсэн хүсэлтийг шийдвэрлэнэ.

\* Багш хүүхэд холбох хүсэлтийг баталсан тохиолдолд эцэг эхэд дараах байдлаар харагдана.

Нүүр

Б.Шүрэнцэцэг (Эцэг, эх)

Миний хүүхдүүд

Хүүхэд сонгох

Хүүхэд нэмэх

ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУМЖ

Хүүхдийн жагсаалт

+ Хүүхэд нэмэх

Эцэг/эхийн овог, нэр	Хүүхдийн овог, нэр	Хүүхдийн регистр	Хамаарал	Сургууль	Хүсэлт илгээсэн огноо	Төлөв
Батболд Шүрэнцэцэг	Мөнхжаргал Энх-Учрал		Эх	Ерөнхий боловсролын Оюунлаг сургууль	2021-04-06	Батлагдсан